

2024 ОНЫ 11 ДҮГЭЭР САРЫН 12-НЫ ӨДРИЙН
ШУУРХАЙ ЗӨВЛӨГӨӨНД НИЙСЛЭЛ, ДҮҮРГИЙН УДИРДАХ
АЖИЛТНААС ӨГСӨН ҮҮРЭГ ДААЛГАВАР

Үүргийн биелэлтийг Arial-12 фонтоор бичиж, **2024 оны 11 дүгээр сарын 20-ны “Лхагва” гарагт** багтаан e-doc системээр албан бичгээр ирүүлж, ТЗУХ-ийн мэргэжилтэн (ERP Б.Одбаяр)-д файлаар ирүүлнэ үү. Хугацаа хэтэрсэн, албан бичгээр ирүүлээгүй тохиолдолд биелэлт ирүүлээгүйд тооцохыг анхаарна уу.

№	Өгсөн үүрэг даалгавар	Хариуцах эзэн
НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГАААС ӨГСӨН ҮҮРЭГ ДААЛГАВАР		
1	Нийслэлийн 2025 оны төсөв батлагдахтай холбогдуулан холбогдох бэлтгэл ажлыг сайтар хангах.	СТСХ
2	Авто замын засвар, арчлалт болон хайс, хашлагыг засварлах ажлыг зохицуулах дүрэм, журмыг боловсруулах, зам хариуцагчийн тогтолцоо руу шилжих саналуудаа нэгтгэн холбогдох байгууллагад хүргүүлэх.	Дүүргийн менежер Г.Дагвадорж, ТХҮХ
3	Дүүргийн төсвөөс нийслэлд төвлөрүүлэх орлогын төлөвлөгөөг биелүүлж, төлөвлөгөөг жигд ханган ажиллах.	СТСХ, Татварын хэлтэс
4	Дүүргүүдэд хот, нийтийн аж ахуйн машин, тоног төхөөрөмжүүдийг хуваарилж, давс, бодисын нөөцлөлт бэлэн байгаа эсэхэд газар дээр нь очиж танилцах чиглэл өгөгдсөний дагуу бэлтгэл, бэлэн байдлыг ханган машин, тоног төхөөрөмжийг хүлээн авч, дараагийн ээлжийн сонгон шалгаруулалтаар нийлүүлэгдэх машин, тоног төхөөрөмж (Цэвэрлэгээний машин)-ыг авах талаар саналыг хүргүүлэх.	Дүүргийн менежер Г.Дагвадорж, ТХҮХ, Багахангай тохижилт ОНӨААТҮГ
5	Хог хаягдлыг ангилах ажлыг нэвтрүүлэх хүрээнд нийслэлээс хэрэгжүүлж буй бодлогын талаар тодруулж, төсөв санхүүжилт, дүүрэг орон нутагт нэвтрүүлэх боломж нөхцөлийг судлах.	Дүүргийн менежер Г.Дагвадорж, ТХҮХ
6	Хэвлэл мэдээлэл, олон нийтэд 2024 оны 11 дүгээр сарын 16-ны өдөр “20 минут”-ын хот, Шинэ Зуунмод хотын танилцуулга, Хот, тосгоны эрх зүйн байдлын шилжилт зэргийг танилцуулахтай холбогдуулан холбогдох албан тушаалтнууд идэвхтэй хамрагдах.	Холбогдох албан тушаалтнууд
7	Нийтийн эзэмшлийн гудамж, зам талбай, орон сууц, гэр хорооллын гэрэлтүүлэг, кабель, шугам сүлжээ, тоног төхөөрөмжийн засвар үйлчилгээг тогтмол хийж, явган замыг стандартад нийцүүлэх ажлыг зохион байгуулж ажиллах.	Дүүргийн менежер Г.Дагвадорж, ТХҮХ, Багахангай Гэрэлтүүлэг, ногоон байгууламж ОНӨААТҮГ
8	Дүүргийн нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулдаг аж ахуйн нэгж, байгууллагын гадна зам талбай, зогсоол, шатахуун түгээх станцуудын орц, гарцын хөдөлгөөний аюулгүй байдлыг хангуулах, замын тэмдэг, тэмдэглэгээ тавих, эвдрэл гэмтлийг засварлуулах ажлыг эрчимжүүлж, дуусгах.	Дүүргийн менежер Г.Дагвадорж, ТХҮХ
9	Өвлийн оргил ачааллын үед эвдрэл гэмтэлгүй, найдвартай, хэвийн ажиллах үүднээс цахилгаан, дулааны инженерийн хангамж, шугам тоноглолын найдвартай ажиллагааг хангах.	Дүүргийн менежер Г.Дагвадорж, ТХҮХ, Инженерийн дэд бүтцийн байгууллагууд
ДҮҮРГИЙН ЗАСАГ ДАРГААС ӨГСӨН ҮҮРЭГ ДААЛГАВАР		
10	2024 оны 11 дүгээр сарын 15-ны өдөр ААНБ-ууд	ТХҮХ,

	ойр орчмынхоо хуваарьт талбай, байгууллагын дотор цэвэрлэгээ үйлчилгээг, 16-ны өдөр гэр хорооллын болон орон сууцны байрны айл өрхүүд ойролцоох талбайн цэвэрлэгээ үйлчилгээг зохион байгуулах.	Хороод, ААНБ-ууд
11	Хүйтний улирал эхэлж байгаатай холбогдуулан иргэд, хүүхэд багачуудыг ханиад томуунаас урьдчилан сэргийлэх үүднээс амны хаалт (маск) зүүж хэвшүүлэх ажлыг сурталчлан таниулах, уриалах.	ЭМТ, Хороод, ЕБС, СӨББ, Нийт байгууллагууд
12	Дүүргийн Онцгой байдлын хэлтсээс өгөгдсөн хугацаатай үүрэг даалгаврыг холбогдох байгууллагууд яаралтай хэрэгжүүлж, биелэлтийг хүргүүлэх, хамтын ажиллагааг сайжруулах.	Холбогдох байгууллагууд
13	Нохой, муур устгах ажлыг зохион байгуулах.	ТХҮХ, Багахангай тохижилт ОНӨААТҮГ, Хороод
14	Олон улсын байгуулагатай хамтран ажиллаж, төсөл хөтөлбөр хэрэгжүүлэх, дэмжлэг туслалцаа хүсэх үйл ажиллагаагаа идэвхжүүлэх.	Нийт байгууллагууд (Төсөл хөтөлбөр хэрэгжиж буй 3 байгууллага)
15	Дүүргийн төсвийн тодотголоор санхүүжилт нь шийдвэрлэгдсэн ажлын гүйцэтгэлийг сайжруулах. (Цагдаагийн постны дэргэдэх Журамлах хашааны гэрэлтүүлэг, камержуулалтын ажлыг гүйцэтгэн сервертэй холбох), холбогдох журмын дагуу үйл ажиллагааг 2024 онд багтаан эхлүүлэх.	ТЗУХ, Цагдаагийн хэлтэс
16	Мал аж ахуй эрхлэхийг хориглосон бүсэд нэвтэрсэн мал, амьтныг хашаажуулах ажлыг эхлүүлэх хүрээнд дүүргийн Засаг даргын захирамжаар байгуулагдсан Ажлын хэсэг ажлаа эрчимжүүлэх.	ЗДО Б.Болормаа, ХААТ, Холбогдох Ажлын хэсэг
17	Хуучин эмнэлгийн зориулалтаар үйл ажиллагаа явуулж байсан Сүрлэн байшинд засвар үйлчилгээ хийгдэж үйл ажиллагаа явуулах боломж нөхцөл бүрдсэн тул цаашид сувиллын зориулалтаар ашиглахаар холбогдох арга хэмжээг авч хэрэгжүүлэх.	ЗДО Б.Болормаа, ТЗУХ, СТСХ, НХХ, ХХҮХ, ЭМТ
18	Иргэдийн амьдрах орчныг сайжруулах хүрээнд хийгдэх “Элстэй талбай, “Зүлэгтэй талбай”, “Зөөврийн ариун цэврийн байгууламж”, “Усан оргилууруудын аюулгүй байдлыг ханган шинэчлэх” зэрэг ажлуудын төсөв санхүүжилтыг 2025 оны төсөвт суулгах, тус ажлуудын гүйцэтгэлд анхаарч, бэлтгэлийг хангах.	СТСХ, Багахангай тохижилт, Гэрэлтүүлэг, ногоон байгууламж ОНӨААТҮГ-ууд
19	ЕБС-ийн “Үдийн цай” хөтөлбөрийг хэрэгжүүлэх ажлын удаашралтын талаар холбогдох байгууллагуудад албан бичгээр уламжилж, гүйцэтгэгчид шаардлага хүргүүлэх.	НХХ
20	Дүүргийн Засаг даргын захирамжаар байгуулагдсан байнгын ажиллагаатай Ажлын хэсгүүд ажлаа эрчимжүүлэх.	Холбогдох Ажлын хэсгүүд
21	Худалдаа үйлчилгээний байгууллагуудаас бараа худалдан авсан талаарх төлбөрийн баримтыг иргэдэд олгох хүрээнд холбогдох шийдвэр, зохицуулалтыг танилцуулж, хэрэгжилтийг хангуулах.	ТХҮХ, Татварын хэлтэс